



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/83

Шивээговь сум

“Сургуулийн сантехникийн засварын
материал худалдан авах” ажлын
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих “Сургуулийн сантехникийн засварын материал худалдан авах” ажлын нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Баасанбат

(Засаг даргын Тамгын газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

З.Баасандалай

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүн:

Г.Батсайхан

(Сумын 1-р багийн иргэн)

2. Худалдан авах ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ